



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 82

Эрдэнэт

Зөвлөл шинэчлэн байгуулах,
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн санал, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сүм, хийд, шашны байгууллагад хяналт, шалгалт хийсэн ажлын хэсгийн саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх "Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтын ёсоор, зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай

2. Үйл ажиллагааныхаа тайланг жил бүрийн 4 дүгээр улиралд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг Зөвлөл /П.Пүрэвхагва/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2008 оны 27 дугаар тогтоол, 2009 оны 67 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100131